



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/740

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлж, тэдэнд гоо зүйн мэдрэмж, зөв төлөвшилтэй болгох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг "Seven melodies" төгөлдөр хуур хөгжмийн сургалтын төвийн 5 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж буй 3 удаагийн сонгодог хөгжмийн тоглолтын үйл ажиллагааны зардалд 200 000 төгрөгийг хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 200 000 төгрөг /Хоёр зуун мянган / -ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5. 17-д тусгагдсан "Спортын аваргууд" дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 11-ний өдрийн
А/740 дүгээр захирамжийн хавсралт



“SEVEN MELODIES” ТӨГӨЛДӨР ХУУР ХӨГЖМИЙН СУРГАЛТЫН
ТӨВИЙН 5 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт зардал
1	Тоглолтын билет хэвлэх	1000	200	200000
	Нийт			200000

-oOo-